



*Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газар*

**ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ ХУУДСАНД МЭДЭЭЛЛИЙГ  
БАЙРШУУЛАХДАА ҮНЭН ЗӨВ, БОДИТОЙ, ИЖ БҮРЭН,  
ОЙЛГОМЖТОЙ, АЧ ХОЛБОГДОЛТОЙ БАЙХ ЗАРЧМЫГ  
ХАНГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

Аудитын код: **ҮАГ-НАГ/2018/01-НА-ХЭ**

Аудитын нэр: **"Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилт**

**ЧИНГИС ХОТ**

**2018 он**

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

<b>ҮГИЙН ТОВЧЛОЛ</b>	<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ</b>
<b>НА</b>	Нийцлийн аудит
<b>УИХ</b>	Улсын их хурал
<b>YAГ</b>	Үндэсний аудитын газар
<b>HAГ</b>	Нийцлийн аудитын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ИНХ</b>	Иргэдийн нийтийн хурал
<b>TEЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>TШЗ</b>	Төсвийн шууд захирагч
<b>CTCX</b>	Санхүү төрийн сангийн хэлтэс
<b>ADBOУC</b>	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ОНӨҮГ</b>	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>TӨХК</b>	Төрийн өмчит хувьцаат компани
<b>TӨААТҮГ</b>	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
<b>TӨҮГ</b>	Төрийн өмчит үйлдвэрийн газар
<b>ЗГБХН</b>	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
<b>TББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>ОНХC</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ЗАА</b>	Захирагчийн ажлын алба
<b>МСҮТ</b>	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
<b>ЕБC</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв
<b>ХЭДС</b>	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

<b>АГУУЛГА</b>			
<b>Ерөнхий зүйл</b>			
<p><b>Тайлан бэлтгэсэн ҮАГ-ын харъяа Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар</b></p>	Товчилсон үгийн жагсаалт	4	
	Аудит хийсэн үндэслэл	5	
	Аудитын зорилт , хамарсан хүрээ	5	
	Аудит хийсэн арга зүй	5-6	
	Үндсэн мэдээлэл	6-7	
<p><b>Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар</b></p> <p><b>Аудитын менежер: Д.Оюунтуяа</b></p> <p><b>Ахлах аудитор: Н.Туяа</b></p> <p style="text-align: center;"><b>2018 оны 11 дүгээр сар</b></p>	<p><b>Нэг. "Шилэн дансны тухай" хуулийн 3.1, 3.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан ч хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.</b></p>		8-15
	<p>1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 - 3.1.2 -т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.</p>		8
	<p>2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мэдээллийг 91.5 хувьтай мэдээлсэн байна.</p>		8-11
	<p>3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.</p>		11-15
<p>4. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлж байна.</p>		15	
<p><b>Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймаг дахь Төрийн Аудитын газрын 7056-2147, 98332147 тоот утас, khentii@audit.gov.mn, 70562112 факсаар харилцана уу.</b></p>	<p><b>Хоёр. Хуулийн 3.1.3, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, мэдээллийг байршуулсан бол 3.1.4-д хамаарах ААН, байгууллагууд хуулийн 6.9-д заасан мэдээллийг байршуулаагүй байна.</b></p>		16-17
	<p>1. Хуулийн 3.1.3 -т заасан байгууллага нь 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлэхээс хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.</p>		16
	<p>2. Хуулийн 3.1.4 -т заасан байгууллагууд 6.9-д заасан мэдээллийг санхүүжилт хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудсанд байршуулаагүй байна.</p>		16-17
<p>3. "Шилэн дансны тухай" хуулийн 3.1.5-д заагдсан байгууллагууд нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж, мэдээллийг 100 хувь байршуулсан байна.</p>		17	

<p><b>Хаяг:</b>  <b>Хэнтий аймаг</b>  <b>Чингис хот</b>  <b>АЗДТГ-ын байр.</b>  <b>320 тоот өрөө</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Гурав. Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн болон дотоод хяналтын үр дүнг сайжруулах шаардлагатай байна.</b></li> </ul>	18-22
	<ol style="list-style-type: none"> <li>1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан аймаг, сумын ИТХ, ИНХ болон 8.2 дахь хэсэгт заасан ТЕЗ-ийн хяналтын үр дүн хангалтгүй байна.</li> </ol>	18-19
	<ol style="list-style-type: none"> <li>2. Хуулийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хяналтыг хэрэгжүүлээгүй байна.</li> </ol>	19
	<ol style="list-style-type: none"> <li>3. Цахим хуудсанд мэдээлсэн мэдээллийн утга агуулга, үнэн зөв, иж бүрэн байдал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.</li> </ol>	20-22
	<ol style="list-style-type: none"> <li>4. Өмнөх аудитаар өгөгдсөн зөрчлийг арилгах албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан ч үр дүн хангалтгүй байна.</li> </ol>	22
	<b>Дөрөв. Дүгнэлт</b>	23
	<b>Тав. Аудитын зөвлөмж</b>	23
	<b>Зургаа. Холбогдох байгууллагын санал</b>	24
	<b>Долоо. ТА-ын тушаал</b>	25
	<b>Найм. Хавсралтууд.....</b>	26
Хэнтий аймгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа /маягт 1.2.3.4.5/		

## **Нэг. АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА**

### **Аудит хийсэн үндэслэл**

Аудитыг “Шилэн дансны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

### **Аудитын зорилт**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг ҮАГ-т тайлагнаж, аймгийн ИТХ-д танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудитыг хийлээ. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1<sup>1</sup>, 3.1.2<sup>2</sup>-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3<sup>3</sup>, 3.1.4<sup>4</sup>, 3.1.5<sup>5</sup>-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

### **Аудитын хамарсан хүрээ**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015-2017 онд хийсэн аудитын дүн, мэдээлэлд үндэслэн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1- д хамаарах 149 байгууллага, ТЭЗ, 3.1.2-д хамаарах 2 ТӨҮГ, 3.1.3-д хамаарах 1 ТӨХК, 3.1.4-д хамаарах улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа 129 ААН, байгууллага, 3.1.5-д хамаарах төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 8 байгууллагыг аудитад түүвэрлэн хамрууллаа.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг шалгахдаа 2017 оны 10, 11,12 сарын мэдээллийг бүрэн байршуулсан эсэхийг хамруулж, зөвлөмж хүргүүлсний дагуу байгууллагууд зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны хагас жилд багтаан ирүүлсэн тул 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг шалгасан.

<sup>1</sup> Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

<sup>2</sup> Төрийн өмчит үйлдвэрийн газрууд

<sup>3</sup> Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжэний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниуд

<sup>4</sup> Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд

<sup>5</sup> Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид

**Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулсан мэдээллийг дансны хуулганы гүйлгээний дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох баримт цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

**Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:**

Аудитад дараахь хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав:

- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

**Үндсэн мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн зарчим нь мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх явдалд үндэслэгдсэн байна.

Шилэн дансны цахим мэдээллийн санд “Шилэн дансны тухай” хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.5-д хамаарах аймаг, сумдын 23 ТЕЗ, орон нутгийн төсвөөс санхүүждэг 152 төсөвт байгууллага, орон нутгийн өмчит 8 хуулийн этгээд, улсын төсвөөс санхүүждэг бусад ТЕЗ-ийн харьяа 33 төсвийн байгууллага, 3 сан, төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар 2, ТӨХК 1, төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэгч 8 байгууллага, нийт 230 цэс нээгдсэн байна.

“Шилэн дансны тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 18 төрлийн, аймгийн ТЕЗ 19 төрлийн, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар 18 төрлийн, 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 7 төрлийн, 3.1.5-т заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 1 төрлийн мэдээлэл оруулахаар цэс нээгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015, 2016 онуудад 2 удаа, 2017 онд 1 удаа тус бүр аудит хийж, хуулийн хэрэгжилтийг тайлагнасан бөгөөд аудитын үр дүнд мэдээллийг байршуулсан хувь жил бүр нэмэгдсэн байна.

2016 онд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар нийт 48 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж 8 албан тушаалтанг ажлаас халж, 24 албан тушаалтанд сануулах, 16 албан тушаалтанд үндсэн цалингийн хувь бууруулах арга хэмжээ авч 100% хэрэгжүүлсэн байна.

2017 онд хийсэн аудитаар “бүх шатны төсвийн захирагчид шилэн данс дахь мэдээллийн үнэн зөв, бодитой иж бүрэн байх зарчмыг ханган ажиллах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгсөн бөгөөд илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлагыг төсвийн 7 байгууллага, 17 сумын Засаг дарга, 3 тосгоны захирагч, 4 хурлын байгууллагад хүргүүлснээс 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулж, мэдээллийг нөхөн байршуулах, зөрчлийг арилгах арга хэмжээ авч 100 хувь хэрэгжүүлжээ.

**Хоёр. АУДИТЫН ДҮН**

Нэгдүгээр  
бүлэг

•“Шилэн дансны тухай” хуулийн 3.1, 3.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан ч хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

**1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1<sup>6</sup>-3.1.2<sup>7</sup>-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.**

А. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах улсын төсвийн 15 ТЕЗ-чийн харьяа төрийн байгууллага 33, сан 3, аймаг, сумын ТЕЗ-чид 23, тэдгээрийн харьяа төрийн байгууллага 152 , ОНӨҮГ 8, ТӨҮГ-ын 2, нийт 221 цэс нээгдэж, хамрагдвал зохих байгууллагууд бүрэн хамрагдсан байна.

Аудитаар улсын төсвийн ТЕЗ-ийн харьяа 33 байгууллага, 3 сан, аймаг, сумын ТЕЗ, түүний харьяа 185 байгууллага нэгжийг тулган шалгахад тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах байгууллагууд бүрэн хамрагдсан хэдий ч цэс нээхдээ зарим байгууллагын төрөл ангиллыг буруу сонгон байршуулсан байна.

- Жаргалтхаан сумын цэс давхар нээгдсэн.
- Төсөвт байгууллагын цонхонд Ахмадын хороо ТББ, Жүржхэн хувийн цэцэрлэг, “Их ирээдүй” хувийн сургууль, “Цэгцүүлэн дом” өрхийн ЭМТ, Халамжийн санг тус тус буруу ангилан цэс нээсэн нь тухайн байгууллагад мэдээлэл байршуулахад хүндрэл үүсгэж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.2-д заасны дагуу “Өндөрхаан Нисэх буудал”, “Авто тээврийн төв” ТӨААТҮГ-ын цэс шилэн дансны цахим хуудаст хамрагдаж, мэдээллээ байршуулсан байна.

**1.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1<sup>8</sup> дэх хэсэгт заасан мэдээллийг 91.5 хувьтай мэдээлсэн байна.**

Аудитад улсын төсвийн ТЕЗ-чдын харьяа 30 төрийн байгууллага, аймаг, сумын 23 ТЕЗ, тэдгээрийн харьяа 119 төрийн байгууллага, 2 ТӨҮГ буюу нийт 151 байгууллагыг хамруулан, тэдгээрийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийг холбогдох тайлан, баримт материал, нотлох зүйлстэй тулган шалгахад дараах байдалтай байна.

“Тогтмол хугацаа”-нд цахим хуудас, мэдээллийн самбараар тайлагнавал зохих нийт 3473 мэдээллээс мэдээлсэн нь 2837 буюу 86.1 хувь, мэдээлээгүй нь 275 буюу 7.9 хувь, хамааралгүй нь 204 буюу 5.9 хувь буюу өмнөх онтой харьцуулбал байршуулсан мэдээлэл 21.1 хувиар өсч, мэдээлээгүй мэдээлэл 6.4 хувиар, хамааралгүй мэдээллийн тоо 14.9 хувиар буурсан байна. Нийт мэдээллийг 91.5 хувьтай мэдээлж, 4.4 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

<sup>6</sup> Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

<sup>7</sup> Төрийн өмчит үйлдвэрийн газар

<sup>8</sup> Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ;



Дээрхи байдлаас үзэхэд мэдээлэл байршуулалт өмнөх оноос сайжирсан байна. Мэдээллийн төрлөөр авч үзвэл:

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан:**

**А.** Тухайн жилийн төсвийг нийт 151 байгууллагын 132 нь хугацаандаа мэдээлж, 8 нь хугацаа хоцроож мэдээлсэн, 1 нь хамааралгүй буюу ажил, гүйлгээ хийгдээгүй байна. Мэдээллийг 93.3 хувь нь байршуулж 10 байгууллага буюу 6.7 хувь нь мэдээлээгүй, тухайлбал;

- Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Зэвсэгт хүчний 232 дугаар анги,
- Өмнөдэлгэр сумын ТЕЗ, ЭМТ, Батширээт, Биндэр сумын ТЕЗ, Гурванбаян тосгоны ТЕЗ, Хэнтий –Ус ХХК

**Б.** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийт 151 байгууллагын 115 нь хугацаандаа мэдээлж, 4 нь хугацаа хоцроож мэдээлэн, 14 нь хамааралгүй буюу ажил, гүйлгээ хийгдээгүй байна. Мэдээллийг 86.9 хувь нь байршуулж, 18 байгууллага буюу 13.1 хувь нь мэдээлээгүй, тухайлбал:

- Эрүүл мэндийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Онцгой байдлын газар, Бор-Өндөр суман дахь МСҮТ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Зэвсэгт хүчний 232 дугаар анги
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Жаргалтхаан сумын ЭМТ, Баянмөнх сумын ЗДТГ, ЭМТ, Хэрлэн сумын ЗДТГ, Баянхутаг сумын ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, Өмнөдэлгэр сумын ЗДТГ, Биндэр сумын ТЕЗ, Гурванбаян тосгоны ЭМТ, Хэнтий-Ус ХХК

**В.** Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг боловсруулж мэдээлбэл зохих нийт 23 ТЕЗ нь 100 хувь мэдээлсэн байна.

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан:**

**А.** Төсвийн гүйцэтгэлийг 12 сарын дунджаар нийт 151 байгууллагаас 141 байгууллага хугацаандаа тогтмол мэдээлж, 8 нь хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээллийг 98,8 хувь нь мэдээлж, 2 байгууллага буюу 1.3 хувь нь мэдээлээгүй. Тухайлбал:

	10-р сар	11-р сар	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	Дундаж
ТЕЗ-ийн НИЙТ ДҮН (байгууллагын тоо)	151	151	151	151	151	151	151	151	151	151	151	151	151
Тийм	146	145	150	132	124	141	142	144	143	143	140	147	141
Үгүй	2	2	1	3	3	0	3	2	0	3	3	0	1.8
Хугацаа хоцорсон	3	4	0	16	24	10	6	5	8	5	8	4	7.8
Хамааралгүй буюу байхгүй, ажил гүйлгээ гараагүй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0.0
Тухайн мэдээллийг мэдээлсэн хувь	98.7	98.7	99.3	98.0	98.0	100.0	98.0	98.7	100.0	98.0	98.0	100.0	98.8

- Баянмөнх сумын ЗДТГ 1 сар, Дэлгэрхаан сумын ТЕЗ 2 сар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар 1 сарын төсвийн гүйцэтгэлийг мэдээлээгүй,
- Аймгийн нийтлэг үйлчилгээ, Хэнтий –Ус ХХК нь сар бүр мэдээлээгүй, улирлаар мэдээлэхдээ

маягтын дагуу бүрэн мэдээлээгүй.

**Б.** Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг нийт 151 нэгж, байгууллагын 141 нь хугацаандаа мэдээлж, 8 нь хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээллийг 98.7 хувь нь байршуулж, 2 байгууллага буюу 1.3 хувь нь байршуулаагүй байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн газар, Хэнтий-Ус ХХК,

**В.** Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг нийт 151 нэгж, байгууллагын 149 нь мэдээлсэн байна. Мэдээллийг 98.7 хувь нь байршуулж, 2 байгууллага буюу 1.3 хувь нь байршуулаагүй байна. Тухайлбал:

- Өлзийт тосгоны ЭМТ, Бор-Өндөр сум дундын Шүүх

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасан** дараа жилийн төсвийн төслийг нийт 151 нэгж, байгууллагын 109 нь хугацаандаа мэдээлж, 2 нь хугацаа хоцроож мэдээлэн, 1 нь хамааралгүй байна. Мэдээллийг 74 хувь нь байршуулж, 39 байгууллага буюу 26 хувь нь мэдээлээгүй байна. Тухайлбал:

- Хэрлэн голын сав газрын захиргаа, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Зооноз өвчин судлалын төв, Уламжлалт анагаах ухааны төв, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Зэвсэгт хүчний 232 дугаар анги, Өндөрхаан Нисэх буудал

- Аймгийн Номын сан, Хан Хэнтий чуулга, Дэлгэрхаан сумын ТЕЗ, Жаргалтхаан сумын ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Хэрлэнбаян-Улаан тосгоны ЕБС, Цэцэрлэг, Галшар сумын ТЕЗ, ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Дархан сумын ТЕЗ, ЕБС, Цэцэрлэг, Хэрлэн сумын ЗДТГ, Өлзийт тосгоны ЗАА, ЭМТ, Дадал сумын ЕБС, Цэцэрлэг, Баянхутаг сумын ТЕЗ, Цэцэрлэг, Батноров сумын ЕБС, Цэцэрлэг, аймгийн Нийтлэг үйлчилгээний газар, Хэнтий-Ус ХХК

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан** хагас жилийн санхүүгийн тайланг 151 байгууллагын 124 нь хугацаандаа мэдээлж, 10 нь хугацаа хоцроож мэдээлсэн, 3 нь хамааралгүй байна. Мэдээллийг 90.5 хувь нь байршуулж, 14 байгууллага буюу 9.5 хувь нь мэдээлээгүй, тухайлбал:

- Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Өндөрхаан Нисэх буудал

- Дэлгэрхаан сумын ТЕЗ, Хэрлэнбаян-Улаан тосгоны ЗАА, ЕБС, ЭМТ, Галшар сумын ТЕЗ, ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Баянмөнх сумын Цэцэрлэг, Батноров сумын Цэцэрлэг

**6.1.4-д** заасан жилийн эцсийн санхүүгийн тайланг 151 байгууллагын 128 нь хугацаандаа мэдээлж, 4 нь хамааралгүй байна. Мэдээллийг 87.1 хувь нь байршуулж, 19 байгууллага буюу 12.9 хувь нь мэдээлээгүй, тухайлбал:

- Бор-Өндөр сум дундын Шүүх, Стандарт хэмжил зүйн хэлтэс, аймгийн Нэгдсэн эмнэлэг,

- Насан туршийн боловсрол төв, Хэрлэнбаян-Улаан тосгоны ТЕЗ, ЗАА, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Дархан сумын ТЕЗ, Бор-Өндөр Бүжинхэн цэцэрлэг, Өлзийт ЭМТ, Баянхутаг сумын ТЕЗ, ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Батноров сумын ЕБС.

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д** заасан аудитын дүгнэлтийг нийт 151 байгууллагын 117 нь хугацаандаа мэдээлж, 5 нь хамааралгүй байна. Мэдээллийг 80.1 хувь нь мэдээлж, 29 байгууллага буюу 19.9 хувь нь мэдээлээгүй, тухайлбал:

- Хэрлэн голын сав газрын захиргаа, Бор-Өндөр дахь сум дундын Прокурорын газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Ус цаг уур орчны шинжилгээний төв,

- Насан туршийн боловсрол төв, Жаргалтхаан ТЕЗ, Хэрлэнбаян-Улаан тосгоны ТЕЗ, ЗАА, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Галшар сумын ЗДТГ, ЭМТ, Баянмөнх сумын ЗДТГ, ЭМТ, Дархан сумын ТЕЗ, Бор-Өндөр сумын Бүжинхэн цэцэрлэг, 2-р цэцэрлэг, Мөрөн сумын ЕБС, Цэцэрлэг, Хэрлэн сумын 6-р цэцэрлэг, Өлзийт тосгоны ЗАА, ЕБС, ЭМТ, Баянхутаг сумын ЗДТГ, Цэцэрлэг, ЭМТ, Батноров сумын ЕБС, Баян-Овоо сумын ТЕЗ

**6.1.5-д** заасан аудитын тайлан, зөвлөмжид тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг нийт 151 байгууллагын 83 нь хугацаандаа мэдээлж, 24 нь хугацаа хоцроож мэдээлсэн, 2 нь хамааралгүй байна. Мэдээллийг 71.8 хувь нь мэдээлж, 40 байгууллага буюу 28.2 хувь нь мэдээлээгүй, тухайлбал:

- Хэрлэн голын сав газрын захиргаа, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Статистикийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Зэвсэгт хүчний 232 дугаар анги,

- Аймгийн ТЕЗ, аймгийн ЗДТГ, Санхүүгийн хяналт, аудитын алба, Насан туршийн боловсрол төв, Дэлгэрхаан сумын ТЕЗ, ЕБС, Хэрлэнбаян-Улаан тосгоны ТЕЗ, Галшар сумын ТЕЗ, ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Дархан сумын ТЕЗ, Хэрлэн сумын ТЕЗ, Тахилгат тосгоны ЗАА, ЭМТ, 6-р цэцэрлэг, 7-р цэцэрлэг, Хүүхдийн ясли, Өлзийт тосгоны ЗАА, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Дадал сумын ЗДТГ, Баянхутаг сумын ТЕЗ, ЗДТГ, Цэцэрлэг, ЭМТ, Батширээт сумын ЕБС, Цэцэрлэг, Биндэр сумын ЕБС, Цэцэрлэг, Норовлин сумын ТЕЗ, Аймгийн Нийтлэг үйлчилгээний газар

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д** заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг нийт 151 байгууллагын 65 нь хугацаандаа мэдээлж, 4 нь хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээллийг 45.7 хувь нь мэдээлж, 80 байгууллага буюу 54.3 хувь нь мэдээлээгүй байна.

**1.3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4<sup>9</sup> дэх хэсэгт заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.**

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>10</sup>-д** заасан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг улсын төсвийн 14 ТЕЗ-ийн харьяа мэдээлбэл зохих 32 байгууллагаас 1 байгууллага буюу 3.1 хувь, аймаг, сумын 23 ТЕЗ тэдгээрийн харьяа мэдээлбэл зохих 119 байгууллагаас 3 буюу 2.5 хувь нь тус тус мэдээллээ байршуулаагүй байна. Тухайлбал:

Зэвсэгт хүчний 232 дугаар анги, Жаргалтхаан сумын ЭМТ, Өлзийт тосгоны Цэцэрлэг, Хэнтий-Ус ХХК

Нийт 151 нэгж, байгууллагын 142 нь хугацаандаа мэдээлж, 5 нь хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээллийг 97.4 хувь нь мэдээлж, өмнөх онтой харьцуулахад 5.8 хувиар өссөн байна.

<sup>9</sup> Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ;

<sup>10</sup> Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;

**Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2<sup>11</sup>** -т заасан хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг улсын төсвийн 15 ТЕЗ-ийн харьяа мэдээлбэл зохих 20 байгууллага 100 хувь байршуулж, аймаг, сумын 23 ТЕЗ тэдгээрийн харьяа мэдээлбэл зохих 82 байгууллагаас 1 буюу Хэнтий-Ус ХХК нь мэдээллээ байршуулаагүй байна.

Нийт 102 нэгж, байгууллагын 99 нь хугацаандаа мэдээлж, 3 нь хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээллийг 99 хувь нь мэдээлж, өмнөх онтой харьцуулахад 0.3 хувиар өссөн байна.

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3<sup>12</sup>**-т заасан тендер, худалдан авалтын мэдээллийг улсын төсвийн 14 ТЕЗ-ийн харьяа мэдээлбэл зохих 32 байгууллагаас 2 байгууллага буюу 6 хувь, аймаг, сумын 23 ТЕЗ тэдгээрийн харьяа мэдээлбэл зохих 119 байгууллагаас 21 буюу 17.6 хувь нь тус тус мэдээллээ байршуулаагүй байна. Тухайлбал:

- Хэнтий аймаг дахь МСҮТ, Эрүүл мэндийн газар

-Хэрлэн сумын ЗДТГ, Тахилгат тосгоны ЭМТ, Өлзийт тосгоны ЗАА, ЭМТ, Баянхутаг сумын ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Галшар, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр, Дадал, Баянхутаг, Батноров, Батширээт, Баян-Адрага, Норовлин сумдын ТЕЗ, Бэрх, Гурванбаян тосгоны ТЕЗ,

Нийт 151 нэгж, байгууллагын 142 нь хугацаандаа мэдээлж, 5 нь хугацаа хоцроож мэдээлсэн, 9 нь хамааралгүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн 4,274.8 сая төгрөгийн 39 худалдан авалтын тендерийн мэдээллийг байршуулж, 2,804.0 сая төгрөгийн 7 тендерийн мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

Цагдаагийн газрын барилга 2,040.0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын барилгын засвар 339.0 сая төгрөг, Ахмадын ордон байгуулах 250,0 сая төгрөг, Автотээврийн төвийн урд талын зам засах 70.0 сая төгрөг, аялал жуулчлалын мастер төлөвлөгөө 40.0 сая төгрөг, сургууль, цэцэрлэгүүдийн ус ариун цэврийн байгууламжийг сайжруулах 40.0 сая төгрөг, Хурх голын төмөр бетон гүүрийн зураг төслийн ажил 25.0 сая төгрөг

Сумдын ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд тендер худалдан авалтын мэдээллийн цонх харагдаж байгаа боловч дээрхи 14 сум, тосгоны нэвтрэх эрхээр ороход тендер худалдан авалтын мэдээллийг шивж оруулах цонх байхгүй, тохиргоо хийгдээгүй учраас мэдээллийг оруулаагүй байна. Энэ нь журмын 7 дугаар зүйлд заасан шилэн дансны нэгдсэн цахим хуудасны үндсэн хэрэглэгч болох нэгдсэн админ, байгууллагын админ, мэдээлэл оруулах хэрэглэгч нарын үйл ажиллагаа, мэдлэг чадвар дутмаг байгаатай холбоотой байна.

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4<sup>13</sup>**-д заасан 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг улсын төсвийн 5 ТЕЗ-ийн харьяа 8 байгууллага, нэгж 683.7 сая төгрөгийн 35 худалдан авалт, аймаг, сумын 23 ТЕЗ, түүний харьяа 27 байгууллага

<sup>11</sup> Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;

<sup>12</sup> Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

<sup>13</sup> Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

1076.6 сая төгрөгийн 94 худалдан авалт буюу нийт худалдан авалтын 18 хувийг тус тус мэдээлээгүй байна. Тухайлбал:

- Бор-Өндөр сум дундын Нэгдсэн эмнэлэг 171.0 сая төгрөгийн 8, аймгийн Халамжийн сан 6.9 сая төгрөгийн 1, аймгийн Нэгдсэн эмнэлэг 160.1 сая төгрөгийн 4, Хэнтий аймаг дахь МСҮТ 30.7 сая төгрөгийн 6, Уламжлалт анагаах ухааны төв 27.9 сая төгрөгийн 2, Боловсрол, соёл урлагийн газар 7.7 сая төгрөгийн 1, Хилийн 0287 дугаар анги 224.9 сая төгрөгийн 7, Онцгой байдлын газар 54.5 сая төгрөгийн 6 худалдан авалт;

- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 97.4 сая төгрөгийн 11, Жаргалтхаан сумын ЕБС 36.5 сая төгрөгийн 3, Цэцэрлэг 22.4 сая төгрөгийн 2, Цэнхэрмандал сумын ЕБС 12.7 сая төгрөгийн 2, Галшар сумын ТЕЗ 32.0 сая төгрөгийн 6, ЗДТГ 9.8 сая төгрөгийн 1, ЕБС 33.8 сая төгрөгийн 3, Цэцэрлэг 27.4 сая төгрөгийн 3, ЭМТ 7.2 сая төгрөгийн 2, Баянмөнх сумын ТЕЗ 16.0 сая төгрөгийн 2, ЗДТГ 5.4 сая төгрөгийн 1, Дархан сумын ТЕЗ 18.0 сая төгрөгийн 2, ЗДТГ 32.8 сая төгрөгийн 4, ЕБС 44.3 сая төгрөгийн 3, Цэцэрлэг 18.3 сая төгрөгийн 2, ЭМТ 15.9 сая төгрөгийн 3, Бор-Өндөр цогцолбор сургууль 23.8 сая төгрөгийн 1, 1-р цэцэрлэг 15.9 сая төгрөгийн 2, Дадал сумын Цэцэрлэг 3.6 сая төгрөгийн 1, Батноров сумын ЭМТ 22.1 сая төгрөгийн 2, Өмнөдөлгөр сумын ТЕЗ 109.9 сая төгрөгийн 10, ЗДТГ 84.0 сая төгрөгийн 3, Батширээт сумын ТЕЗ 161.1 сая төгрөгийн 12, Биндэр сумын ТЕЗ 210.3 сая төгрөгийн 9, Цэцэрлэг 5.0 сая төгрөгийн 1, Баян-Адрага сумын ТЕЗ 10.0 сая төгрөгийн 2 худалдан авалтыг тус тус мэдээлээгүй.

Худалдан авалт нь нийт дүнгээр 5.0 сая төгрөгт хүрсэн боловч 1 удаагийн төлбөрийн дүн 5.0 сая төгрөгт хүрээгүй гүйлгээг орхигдуулсан нь зөрчил гарч байгаагийн нэг гол шалтгаан болж байна.

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5<sup>14</sup>-д** заасан 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг улсын төсвийн 15 ТЕЗ-ийн харьяа 32 байгууллагын 32,850.4 сая төгрөгийн 482 орлогын гүйлгээнээс 14 байгууллага 5,361.2 сая төгрөгийн 103 гүйлгээг, аймаг, сумын харьяа 119 байгууллагын орлогын 30,983.6 сая төгрөгийн 1196 гүйлгээнээс 37 байгууллага 4,578.1 сая төгрөгийн 210 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна. Тухайлбал:

- Татварын хэлтэс 440.5 сая төгрөгийн 9, Бор-Өндөр сум дундын Нэгдсэн эмнэлэг 319.6 сая төгрөгийн 11, Бэрх сум дундын нэгдсэн эмнэлэг 379.7 сая төгрөгийн 9, аймгийн Прокурорын газар 329.7 сая төгрөгийн 9, Статистикийн хэлтэс 34.1 сая төгрөгийн 6, Зооноз өвчин судлалын төв 24.3 сая төгрөгийн 1, Биндэр сум дундын нэгдсэн эмнэлэг 305.2 сая төгрөгийн 8, Биеийн тамир спортын газар 110.1 сая төгрөгийн 9, Уламжлалт анагаах ухааны төв 25.2 сая төгрөгийн 1, Хилийн 0287 дугаар анги 1,633.0 сая төгрөгийн 20, Бор-Өндөр суман дахь МСҮТ 15.2 сая төгрөгийн 2, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар 88.7 сая төгрөгийн 6, Зэвсэгт хүчний 232 дугаар анги 557.0 сая төгрөгийн 10, ХЭДС 1,098.9 сая төгрөгийн 2 орлогын гүйлгээг;

- Аймгийн ЗДТГ 209.8 сая төгрөгийн 3, аймгийн Номын сан 86.5 сая төгрөгийн 11, Орон нутгийн өмчийн газар 76.1 сая төгрөгийн 9, Хан Хэнтий чуулга 346.1 сая төгрөгийн 6, Дэлгэрхаан сумын Цэцэрлэг 18.0 сая төгрөгийн 1, Цэнхэрмандал сумын ЗДТГ 62.7 сая төгрөгийн 4, Галшар сумын ЗДТГ 73.5 сая төгрөгийн 5, ЭМТ 59.1 сая төгрөгийн 3, Баянмөнх сумын ЗДТГ 183.9 сая төгрөгийн 10, ЕБС 208.9 сая төгрөгийн 6, Цэцэрлэг 134.5 сая төгрөгийн 8, ЭМТ 129.2 сая төгрөгийн 7, Дархан сумын ЕБС 27.1 сая төгрөгийн 2, Цэцэрлэг 25.2 сая төгрөгийн 2, Бор-Өндөр цогцолбор

<sup>14</sup> Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

сургууль 173.6 сая төгрөгийн 2, 1-р цэцэрлэг 49.1 сая төгрөгийн, Бүжинхэн цэцэрлэг 168.1 сая төгрөгийн 5, Хэрлэн сумын ЗДТГ 334.6 сая төгрөгийн 6, 4-р сургууль 37.7 сая төгрөгийн 1, Дадал сумын ЗДТГ 40.4 сая төгрөгийн 4, ЕБС 163.1 сая төгрөгийн 5, Цэцэрлэг 65.9 сая төгрөгийн 5, ЭМТ 37.9 сая төгрөгийн 2, Баянхутаг ЗДТГ 78.6 сая төгрөгийн 4, ЕБС 39.8 сая төгрөгийн 3, Өмнөдэлгэр сумын ЭМТ 22.6 сая төгрөгийн 1, Батширээт сумын ЕБС 78.2 сая төгрөгийн 4, Цэцэрлэг 27.4 сая төгрөгийн 2, Биндэр сумын ЗДТГ 23.4 сая төгрөгийн 1, ЕБС 611.4 сая төгрөгийн 18, Цэцэрлэг 264.7 сая төгрөгийн 11, Гурванбаян тосгоны ЗАА 123.7 сая төгрөгийн 12, ЕБС 293.1 сая төгрөгийн 15, Цэцэрлэг 100.5 сая төгрөгийн 11, ЭМТ 154.4 сая төгрөгийн 10 орлогын гүйлгээг мэдээлээгүй.

Дээрхи байгууллагууд нь 5.0 сая төгрөгөөс дээш санхүүжилтийн орлогын гүйлгээг мэдээлээгүй нь зөрчлийн дүнд нөлөөлж байна.

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5<sup>15</sup>-д** заасан цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг улсын төсвийн 15 ТЕЗ-ийн харьяа 32 байгууллагын 13,484.4 сая төгрөгийн 542 зарлагын гүйлгээнээс 6 байгууллага 829.7 сая төгрөгийн 87 гүйлгээг, аймаг, сумын харьяа 119 байгууллагын зарлагын 6,092.4 сая төгрөгийн 395 гүйлгээнээс 23 байгууллага 687.2 сая төгрөгийн 64 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна. Тухайлбал:

- Уламжлалт анагаах ухааны төв 5.1 сая төгрөгийн 1, Хилийн 0287 дугаар анги 464.0 сая төгрөгийн 29, Онцгой байдлын газар 55.6 сая төгрөгийн 6, Бор-Өндөр суман дахь МСҮТ 36.0 сая төгрөгийн 3, Зэвсэгт хүчний 232 дугаар анги 19.5 сая төгрөгийн 2, ХЭДС 249.5 сая төгрөгийн 46 зарлагын гүйлгээг;

- Аймгийн ЗДТГ 199.7 сая төгрөгийн 16, Санхүүгийн хяналт, аудитын алба 9.1 сая төгрөгийн 1, Байгаль орчин, аялал жуулчлалын газар 97.4 сая төгрөгийн 11, Хан хэнтий чуулга 20.4 сая төгрөгийн 2, Галшар сумын ЕБС 21.9 сая төгрөгийн 1, Цэцэрлэг 28.4 сая төгрөгийн 3, Баянмөнх сумын ЗДТГ 5.0 сая төгрөгийн 1, ЕБС 25.8 сая төгрөгийн 3, Цэцэрлэг 28.4 сая төгрөгийн 3, Бор-Өндөр сумын 1-р цэцэрлэг 17.4 сая төгрөгийн 3, Бүжинхэн цэцэрлэг 32.9 сая төгрөгийн 4, Хэрлэн сумын ЗДТГ 18.2 сая төгрөгийн 3, 4-р сургууль 32.7 сая төгрөгийн 2, 6-р цэцэрлэг 7.5 сая төгрөгийн 1, 7-р цэцэрлэг 6.5 сая төгрөгийн 1, 8-р цэцэрлэг 12.3 сая төгрөгийн 1, Дадал сумын ЕБС 13.2 сая төгрөгийн 1, Баянхутаг сумын ЕБС 6.7 сая төгрөгийн 1, Өмнөдэлгэр сумын ЗДТГ 65.0 сая төгрөгийн 2, Батширээт сумын ЗДТГ 10.0 сая төгрөгийн 1, Цэцэрлэг 17.3 сая төгрөгийн 1, Биндэр сумын ЕБС 6.4 сая төгрөгийн 1, Цэцэрлэг 5.0 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй.

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6<sup>16</sup>-д** заасан худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг нийт мэдээлбэл зохих 151 байгууллагаас 149 байгууллага буюу 98.2 хувь нь мэдээлж, 2 буюу 1.8 хувь нь мэдээлээгүй байна. Тухайлбал:

Жаргалтхаан сумын ЕБС, Өлзийт сумын ЭМТ

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7<sup>17</sup>-д** заасан байгууллагын батлагдсан орон тоонд

<sup>15</sup> Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

<sup>16</sup> Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;

<sup>17</sup> Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;

өөрчлөлт орсон мэдээллийг нийт мэдээлбэл зохих 151 байгууллагаас 3 буюу 2 хувь нь мэдээлээгүй байна. Тухайлбал:

Статистикийн хэлтэс, Мөрөн сумын ЕБС, Хэнтий-Ус ХХК

**Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>18</sup>**-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг улсын төсвийн 15 ТЕЗ-ийн харьяа 32 байгууллагын нийт 272 шийдвэрээс 6 байгууллага 92.9 сая төгрөгийн 152 шийдвэр буюу 55.9 хувийг, аймаг, сумын 23 ТЕЗ, түүний харьяа байгууллагын 955 шийдвэрээс 38 байгууллага 596.3 сая төгрөгийн 385 шийдвэр буюу 43.8 хувийг мэдээлээгүй байна. Тухайлбал:

- Бор-Өндөр сум дундын Шүүх 4.0 сая төгрөгийн 4, аймгийн Нэгдсэн эмнэлэг 10.1 сая төгрөгийн 11, Ус цаг уур орчны шинжилгээний төв 3.8 сая төгрөгийн 9, Биндэр Сум дундын нэгдсэн эмнэлэг 12.8 сая төгрөгийн 28, Биеийн тамир спортын газар 52.9 сая төгрөгийн 92, Боловсрол, соёл урлагийн газар 9.3 сая төгрөгийн 8 тушаал;
- Аймгийн ЗДТГ аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах 187.4 сая төгрөгийн 58 захирамж, Тамгын газрын даргын хөрөнгө зарцуулах 32.4 сая төгрөгийн 19 тушаал

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэл байршуулах хэсэгт “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн олон төрлийн мэдээлэл нэг дор байршигдсанаар хуулийг хэрэгжүүлж буй байгууллага ойлголтын зөрүү үүсч, зөрчил гарах нөхцлийг бүрдүүлж байна.

#### **1.4. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлж байна.**

Хуулийн 5.7-д заасны дагуу орон нутгийн төсөв, түүний төсөв захирагчийн шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуулийн 5.8<sup>19</sup>-д заасан шаардлагын дагуу мэдээлж байна.

Аудитын явцад хийсэн судалгаагаар нийт байгууллагууд нь мэдээллийн самбар ажиллуулж, олон нийтэд мэдээллийг хүргэх нөхцөл боломжоор ханган, хуулийг хэрэгжүүлж байна.

Шилэн дансны мэдээллийн самбарт мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж буй эсэхэд төсөв захирагч нар болон ИТХ-ын байгууллагаас хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

<sup>18</sup> Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

<sup>19</sup> Мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

Хоёрдугаар  
бүлэг

•Хуулийн 3.1.3, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, мэдээллийг байршуулсан бол 3.1.4-д хамаарах ААН, байгууллагууд хуулийн 6.9-д заасан мэдээллийг байршуулаагүй байна.

**2.1. Хуулийн 3.1.3<sup>20</sup>-т заасан байгууллага нь 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлэхээс хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.**

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д хамаарах “Харгуй” ТӨХК компани нь хуулийн 6.8<sup>21</sup>-д заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Шилэн дансны цахим хуудаст 7 төрлийн мэдээлэл байршуулахаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний 451.3 сая төгрөгийн 9 тендерийн мэдээлэл, хувийн ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл 30, 10.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулахтай холбоотой 14 тушаал шийдвэрийг байршуулсан байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллага төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3<sup>22</sup> -т заасны дагуу мэдээлсэн нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1<sup>23</sup>-д нийцээгүй тул холбогдох журмыг хуулийн 6.8.1-д нийцүүлэх шаардлагатай байна.

**2.2. Хуулийн 3.1.4<sup>24</sup>-т заасан байгууллагууд 6.9-д заасан мэдээллийг санхүүжилт хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудсанд байршуулаагүй байна.**

Хуулийн 3.1.4-т заасан улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд 6.9-д заасан мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх цонхыг тодорхой болгоогүйтэй холбоотой байна.

Аудитаар хийсэн судалгаагаар 6.9-д заасны дагуу мэдээлбэл зохих улс, орон нутгийн төсөв, ОНХС-гийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа 8,126.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг гүйцэтгэгч 129 ААН, байгууллагад 5,546.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, санхүүжилт өгсөн байгууллага өөрийн шилэн дансны “**хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл**” цэст мэдээлсэн байна. Үүнд:

- Улсын төсвийн 3,290.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 хөрөнгө оруулалтанд нийт 1,942.4 сая төгрөгийн санхүүжилт олгосныг шилэн дансанд бүртгэсэн байна.

<sup>20</sup> Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани

<sup>21</sup> Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

<sup>22</sup> “... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр ...”

<sup>23</sup> Тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр

<sup>24</sup> Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд



- *Орон нутгийн төсвийн 1,141.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 хөрөнгө оруулалтанд нийт 878.5 сая төгрөгийн санхүүжилт олгосныг шилэн дансанд мэдээлсэн байна.*
- *Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 1,740.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 хөрөнгө оруулалтанд нийт 958.3 сая төгрөгийн санхүүжилт олгосныг шилэн дансанд мэдээлсэн байна.*
- *Замын сангийн хөрөнгөөр 123.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 арга хэмжээнд 119.8 сая төгрөгийн санхүүжилт олгосныг шилэнд дансанд мэдээлсэн байна.*
- *Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчдийн хүрээнд нийт 1,830.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 64 хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шилэн дансанд мэдээлсэн байна.*

### **2.3. “Шилэн дансны тухай” хуулийн 3.1.5-д заагдсан байгууллагууд нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж, мэдээллийг 100 хувь байршуулсан байна.**

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр нийт 637.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил үйлчилгээг 8 аж ахуйн нэгж гэрээгээр гүйцэтгэж байна. Үүний 4 нь өрхийн эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг ЗГБХН, 2 нь хүүхдийн цэцэрлэгийн үйлчилгээ үзүүлдэг компани, 1 нь бага боловсрол олгодог сургууль, 1 нь аймгийн Ахмадын хороо буюу төрийн бус байгууллага байна.

Гэрээнд тусгасан ажил үйлчилгээг төсвийн хуваарийн дагуу 2018 онд нийт 496.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба үйл ажиллагааны хэрэгжилт гүйцэтгэл 79.8 хувьтай байна.

Санхүүжилтийг улирал бүр хуваарийн дагуу олгосон ба тухай бүр шилэн дансанд бүрэн мэдээлсэн байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу санхүүжиж байгаа 4 нэгж байгууллага шилэн дансны мэдээллийг төсвийн байгууллагын нэгэн адил тусгай цэст байршуулдаг нь хуулийн 6.9<sup>25</sup>-д заасантай нийцэхгүй байна. Үүнд:

*Ахмадын хороо ТББ, Жүржхэн цэцэрлэг ТББ, Бор-Өндөр сумын Цэгцүүлэн өрхийн эрүүл мэндийн төв ЗГБХН, Их ирээдүй хувийн сургуулийг “төсөвт байгууллага” гэсэн ангиллаар цахим хуудсанд цэс нээсэн байгааг залруулах шаардлагатай байна.*

Хэрлэн дом, Ач манал, Оюуны шим өрхийн эрүүл мэндийн төвүүд гэрээний дүнг улирлаар мэдээлсэн, нягтлан бодогчийн нэр, утасны дугаарыг шинэчилж оруулаагүй, Бор-Өндөр Цэгцүүлэн дом өрхийн эмнэлэг даргын нэр, утасны дугаарыг шинэчилж мэдээлээгүй нь хуулийн 5.1.3<sup>26</sup> дахь заалтад нийцэхгүй байна.

<sup>25</sup> ....энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай бол олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно.

<sup>26</sup> Тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх.

Гуравдугаар  
бүлэг

•Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн болон дотоод хяналтын үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

**3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан аймаг, сумын ИТХ, ИНХ болон 8.2 дахь хэсэгт заасан ТЕЗ-ийн хяналтын үр дүн хангалтгүй байна.**

**А. Хуулийн 8.1-д заасан аймаг, сумын ИТХ, ИНХ-аас хэрэгжүүлэх хөндлөнгийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.**

1. Хуулийн 8.1-д зааснаар хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны ИТХ, иргэдийн нийтийн хурал хэрэгжүүлэхээр заасан боловч аймаг, сумын ИТХ-аас хяналт тавьсан талаарх мэдээлэл хангалтгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 19-нд “Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг төсвийн байгууллагуудад шалгах ажлын удирдамж”-ийг 2018 оны 05 дугаар сарын 29-нд ИТХ-ын дарга баталж, Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, төсөв, өмчийн хорооны гишүүд 30 байгууллагын 2018 оны эхний хагас жилийн шилэн дансны мэдээлэлд хяналт шалгалт хийсэн.” талаарх албан бичгийг ирүүлжээ.

Аудитад Дадал, Өмнөдэлгэр, Дэлгэрхаан, Мөрөн, Галшар сумын ИТХ-ын байгууллагууд хяналт шалгалт хийж, байгууллагын нягтлан бодогч нарт заавар зөвлөмж өгч ажилласан тухай тайлан мэдээ, 16 сумын ИТХ-ын байгууллага зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч ажилласан тухай албан бичгийг ирүүлсэн байна.

Гэвч аудитын явцад хяналт, шалгалт хийж, заавар зөвлөмж өгөгдсөн сумдын төсөвт байгууллагуудад мэдээллийг мэдээлээгүй, мэдээллийн утга агуулгыг үнэн зөв, иж бүрэн байршуулаагүй зөрчил илэрч байгаа нь хяналт шалгалтын үр дүн хангалтгүй байгааг харуулж байна.

Дээрхи байдлаас үзэхэд ИТХ-ын байгууллагын ажилтнууд шилэн дансны мэдээлэлд хяналт тавихдаа мэдээллийн утга агуулга, иж бүрэн байх шаардлагад нийцсэн эсэх, мөн мэдээллийн самбарт мэдээллийг тухай бүр шинэчлэн, тогтмол ажиллуулж буй эсэхийг анхаарч үзэх шаардлагатай байна.

**Б. Хуулийн 8.2-д заасан ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны хэрэгжүүлсэн дотоод хяналт, шалгалтын үр дүн хангалтгүй байна.**

2. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 8.5 заалтыг удирдлага болгон хяналтыг хэрэгжүүлж байна.

1. Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба “Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2018 оны эхний 3 улирлын явцад хяналт тавьж ажилласан байдал. 1. 2018 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар 42 байгууллага, сангуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, дотоод аудит хийгдсэн. 2. Шилэн дансны тайлан илгээлт улирал бүрийн

тайлангийн ирцийг хангуулах, мэдээллийн үнэн зөв, бодитой байх талаар хяналт тавьж, тайлан ирүүлээгүй болон хугацаа хоцроосон байгууллагуудад хариуцлага тооцож байх талаар Төрийн захиргаа удирдлагын хэлтсээр дамжуулан аймгийн Засаг даргад уламжлан ажиллаж байна. 3. Хийгдсэн ажлын бичмэл тайлан, 2018 оны 1,2-р улирлын тайлангийн ирцийн бүртгэлийг гаргаж хавсралтаар хүргүүлэв.” гэсэн 2018 оны 10 сарын 15-ны 35 тоот албан бичгийг ирүүлсэн байна.

2. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын эхний 3 улиралд Сангийн яаманд илгээсэн тайлантай танилцахад мэдээлэл байршуулалт 98.4 хувьтай байна. Үүнд: Хэрлэн сумын 4-р сургууль , Насан туршийн боловсрол төв, Хэнтий-Ус ХХК зэрэг 3 байгууллага хугацаа хоцроосон, аймгийн ИТХ, Хэнтий аймгийн нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ, Баянхутаг сумын цэцэрлэг 2 удаа , Соёлын төв зэрэг байгууллагууд тайлан илгээгээгүй байна.

	Аймгийн ТЕЗ-ийн нийт харьяа	хугацаандаа		хугацаа хоцроосон		тайлан илгээгүй	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1-р улирал	168	167	99.4	1	0.6		
2-р улирал	168	163	97.0		0.0	5	3.0
3-р улирал	168	166	98.8	1	0.6	1	0.6
<b>дүн</b>	<b>168</b>		<b>98.4</b>	<b>2</b>	<b>1.2</b>	<b>6</b>	<b>3.6</b>

Хэдийгээр тайлангийн ирц сайжирч байгаа боловч байршуулсан мэдээллийн агуулга, үнэн зөв болон иж бүрэн байдал учир дутагдалтай, мэдээлэл оруулж байгаа албан тушаалтнуудын мэдлэг, чадвар хангалтгүй, ойлголт янз бүр байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт тавьж ажилладаг боловч зөвлөмжийн хэрэгжилтэд дүгнэлт хийж ажиллахгүй байгаагаас аудитад хамрагдсан байгууллага, хуулийн этгээд нь мэдээллийг бүрэн, үнэн зөв оруулдаггүй, хагас дутуу оруулдаг, эсвэл байхгүй гэж мэдээлдэг, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг оруулдаггүй, хугацаа хоцроож мэдээлдэг зөрчил дутагдал давтагдсаар байна.

Иймээс аймгийн ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хийсэн хяналт шалгалт, өгсөн заавар зөвлөмжийн үр дүн хангалтгүй байгаа учраас байгууллагын мэдээлэл байршуулах ажилтнуудын мэдлэг, чадварыг сайжруулах шаардлагатай байна.

### 3.2 Хуулийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Хуулийн 3.1.3-д хамаарах Харгуй ТӨХК, 3.1.4-д хамаарах 129 ААН, байгууллага, 3.1.5-д хамаарах 8 ААН, байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналтыг хэрэгжүүлсэн талаар ямар нэгэн мэдээ тайлан байхгүй байна.

Үүнд 3.1.4, 3.1.5 -д хамаарах ААН, байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтан, хариуцлагын талаар журамд нарийвчлан тусгаагүй байгаа нь нөлөөлж байгаа бөгөөд цаашид журамд тодорхой тусгах шаардлагатай.

### 3.3 Цахим хуудсанд мэдээлсэн мэдээллийн утга агуулга, үнэн зөв, иж бүрэн байдал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Цахим хуудсанд мэдээллийг байршуулахдаа зарим байгууллагууд утга агуулгыг үнэн зөв оруулаагүй, мэдээллийн маягтыг бүрэн бөглөөгүй, оруулвал зохих мэдээллийг байршуулдаггүй, файл хавсаргаж байршуулаагүй зэргээс шалтгаалан оруулсан мэдээлэл нь иргэд олон нийт танилцахад ойлгомжгүй байна. Энэ нь хуулийн 4.1.1<sup>27</sup>, 4.1.2<sup>28</sup> дахь шилэн дансны зарчимтай нийцэхгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь ажил хариуцаж байгаа албан тушаалтнуудын мэдээлэл байршуулах ойлголт, мэдлэг чадвар хангалтгүй байгаатай холбоотой байна.

Шилэн дансны мэдээлэл байршуулах үзүүлэлтийн утга, агуулгын талаар нэгдсэн ойлголтыг бүрэн өгөөгүйгээс ажилтан бүр өөр өөрийн ойлголтоор мэдээллийг байршуулж байгаагаас хөрөнгө зарцуулах шийдвэрийг файлаар хавсаргаагүй, батлагдсан төсөв, гүйцэтгэлийг мэдээлэхдээ зардлын ангиллыг дансны кодоор оруулсан, нийт дүнгүй, хавсаргасан файлын үсгийн фонд танигдахгүй, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтад санхүүжилтийн гүйлгээг мэдээлсэн, тендерийн мэдээллийн маягтыг бүрэн бөглөөгүй, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг “байхгүй” гэж мэдээлсэн зэрэг нийтлэг зөрчил дутагдалууд гарч байна. Тухайлбал:

1. Дараа жилийн төсвийн төслийг мэдээлэхдээ: Хан Хэнтий чуулга хамааралгүй мэдээ оруулсан, Цэнхэрмандал сумын ЕБС унших боломжгүй бүдэг файл оруулсан, Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэг сургуулийн төсвийг оруулсан, Дэлгэрхаан сумын ЕБС, Статистикийн хэлтэс үсгийн фонд танигдахгүй файл оруулсан, Өндөрхаан Нисэх буудал 2018 оны орлого зарлагын төлөвлөгөөг байршуулсан.
2. Хөрөнгө зарцуулах тушаал шийдвэрийг мэдээлэхдээ: Хөрөнгө зарцуулах шийдвэрийг файлаар хавсаргаагүй, маягтыг бүрэн бөглөөгүй. Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлэг өр, авлагын мэдээ оруулсан, Хэрлэнбаян-Улаан тосгоны Цэцэрлэг шийдвэрийн хуулбарыг оруулаагүй.
3. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийг мэдээлэхдээ: Аймгийн ЗДТГ, Халамжийн сан, Хэрлэн голын сав газрын захиргаа нь эдийн засгийн ангиллыг дансны кодоор оруулсан нь ойлгомжгүй байна.
4. 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтыг мэдээлэхдээ:

Хан Хэнтий чуулга тухайлбал халаалтын худалдан авалтын гэрээний дүн 36.3 сая төгрөг байхад 5.1 сая төгрөг гэж, худалдан авалтын санхүүжилт өссөн дүнгээр 20.7 сая төгрөг байхад 24.5 сая төгрөг гэж зөрүүтэй мэдээлсэн байна.

Мөн худалдан авалтын санхүүжилт хэсэгт тухайн мэдээлэлтэй хамааралгүй мэдээлэл оруулсан байна.

<sup>27</sup> Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх

<sup>28</sup> Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх

Мөн санхүүжилтийн гүйлгээг мэдээлсэн: Аймгийн ТЕЗ, Өмнөдэлгэр сумын ТЕЗ, Биндэр сумын Цэцэрлэг, Хэрлэн голын сав газрын захиргаа сарын санхүүжилт, зарлагын дүнг мэдээлсэн.

Бор-Өндөр сумын 1-р цэцэрлэг худалдан авалтыг сар бүр мэдээлсэн боловч өссөн дүнгээр мэдээлээгүй,

5. 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээг мэдээлэхдээ: Хэрлэн сумын 4-р сургууль 37.7 сая төгрөгөөр, Мөрөн сумын Цэцэрлэг 187.5 сая төгрөгөөр, Өлзийт тосгоны ЗАА 10.5 сая төгрөгөөр, Ус цаг уур орчны шинжилгээний төв 5.7 сая төгрөгөөр илүү мэдээлсэн, Хэрлэн голын сав газрын захиргаа тухайн сарын зарлагын дүнг мэдээлсэн,
6. Тендерийн мэдээллийн маягыг бүрэн бөглөөгүй.
7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг “байхгүй” гэж мэдээлсэн.
8. ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт хэсэгт мэдээлэхдээ: Бор-Өндөр сум дундын Прокурорын газар мэдээллийг байршуулаагүй нүүр хэсгийг оруулсан, Галшар сумын ЭМТ дүгнэлтийг PDF файлаар байршуулаагүй, Баянмөнх сумын ЗДТГ хамааралгүй мэдээлэл байршуулсан,
9. Аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлэхдээ: Аймгийн ТЕЗ аудитын дүгнэлт тайланг оруулсан.
10. Хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлэхдээ: Баянмөнх сумын цэцэрлэг хамааралгүй мэдээлэл оруулсан, Өндөрхаан Нисэх буудал аудитын зөвлөмжийн хариуг байршуулсан.
11. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг Баян-Адрага сумын ТЕЗахирагч мэдээлээгүй.
12. Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлэхдээ: Аймгийн нийтлэг үйлчилгээний газар, Хэнтий-Ус ХХК, Өндөрхаан Нисэх буудал сар бүр мэдээлээгүй, улирлаар мэдээлэхдээ маягын дагуу утга агуулгыг бүрэн мэдээлээгүй.
13. Хэрлэн дом, Ач манал, Оюуны шим өрхийн эмнэлгүүд гэрээнд тусгагдсан санхүүжилтийн дүн хэсэгт улирлын дүнг мэдээлсэн.

Энэ нь олон нийтэд зөрүүтэй, дутуу мэдээлэл хүрэх, ил тод байдал бүрэн хангагдахгүй байх нөхцөл үүсч, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн ач холбогдолыг бууруулах үр дагавартай байна.

Мөн Хэрлэн сумын 1, 2,4-р цэцэрлэг, Мөрөн сумын ЕБС, Цэцэрлэг, Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлэг, Хот тохижилт, аймгийн Нийтлэг үйлчилгээний газар зэрэг байгууллагууд нь нягтлан бодогчийн овог нэр, холбогдох утасны дугаарыг шинэчилж оруулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 5.1.3<sup>29</sup> дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь байгууллагын админ, мэдээлэл оруулах ажилтнууд үүргээ хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

<sup>29</sup> “тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх”

Цахим хуудсанд “ТЕЗ-ийн /төсөвт байгууллагын/ батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” мэдээллийг сар бүр, “тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт” –ийг тухай бүр мэдээлэхдээ адилхан мэдээллийг 2 дахин шивж оруулж байгаа нь ажилтнуудад хүндрэл үүсгэдэг байна.

**3.4 Өмнөх аудитаар өгөгдсөн зөрчлийг арилгах албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан ч үр дүн хангалтгүй байна.**

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-т 1, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 1, аймаг, сумын Засаг дарга нарт 1, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнийн агентлаг, газар, хэлтэс, албаны дарга нарт 1, бүх шатны ИТХ-ын байгууллагуудад 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

1. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс өгөгдсөн зөвлөмжийн дагуу:

- А. Нутаг дэвсгэрийн харъяаллаар улсын төсвийн 20 байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгийн 4, аймгийн Засаг даргын төсвийн багцад харъяалагддаг 4 байгууллага Хэрлэн суманд бүртгэлтэй байгааг залруулж аймгийн харьяа болгон бүртгэсэн байна.
- Б. Цөм сүргийн үржлийн төв, Улсын нөөцийн салбар татан буугдсаныг шилэн дансны цэсийн жагсаалтаас хасуулах албан тоотыг Сангийн яаманд хүргүүлж хасуулсан байна.
- В. Мэдээллийн нууцлалтай 2, бие даасан санхүүгийн тайлан гаргадаггүй 1 байгууллагуудад шилэн дансны бүртгэлээс хасуулах, мэдээллээ өөрийн байгууллагын сайт дээр байршуулж байх зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

2. Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг бэлтгэн хавсаргах талаар бүх шатны төсвийн захирагч нарт хүргүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлсэн ч үр дүн хангалтгүй байна.

3. Аймаг, сумын Засаг дарга нарт хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээ, түншлэлийн гэрээний дагуу санхүүжилт авсан этгээдтэй байгуулах гэрээнд хуулийн 6.9-д заасан мэдээллийг улирал тутам санхүүжилт хүлээн авсан байгууллагын цахим хуудаст мэдээлэх заалтыг тусгах зөвлөмжийн хэрэгжилт 88.9 хувьтай байна.

4. Бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагуудад “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэнд тавих хөндлөнгийн хяналтыг улам эрчимжүүлэх зөвлөмжийг 94.4 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Өмнөх аудитаар: 1.Зөрчлийн арилгуулах хугацаатай албан шаардлагыг төсвийн 7 байгууллага, 17 сумын Засаг дарга, 3 тосгоны захирагч, 4 хурлын байгууллагад хүргүүлснээс хэрэгжилт 100 хувьтай байна.

**Аудитаар нийт 16,709.7 төгрөгийн мэдээллийг байршуулаагүй, зөрүүтэй мэдээлсэн 43 төрлийн зөрчил илрүүлж, ТЕЗ, холбогдох албан тушаалтанд цаашид шилэн дансны үйл ажиллагааг сайжруулах, зөрчлийг арилгах талаар 5 зөвлөмжийг хүргүүллээ.**

### Дөрөв. ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. “Шилэн дансны тухай” хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.5-д хамаарах байгууллагуудын мэдээлэл байршуулалтын хувь өмнөх оноос өссөн байна.
2. “Шилэн дансны тухай” хуулийн 3.1.4-д хамаарах байгууллагуудын мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах цонх тодорхойгүй, тавих хяналтын талаар журамлаагүй байгаагаас хэрэгжилт хангалтгүй байна.
3. Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6.1, 6.4-д заасан мэдээллийг мэдээлсэн боловч зарим байгууллагуудын мэдээлийн утга агуулга, үнэн зөв, иж бүрэн байдал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.
4. “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг нарийвчлан сайжруулж, цахим хуудсанд мэдээллийг ойлгомжтой, цэгцтэй, давхардуулахгүйгээр байршуулах, мэдээлэл байршуулах ажилтнуудад үүргээ хэрэгжүүлэхэд хялбар байхаар зохион байгуулах шаардлагатай байна.
5. Шилэн дансны мэдээллийг байршуулах болон хяналт хэрэгжүүлэх албан тушаалтнуудад нэгдсэн ойлголтод хүрэх талаар сургалт зохион байгуулах шаардлагатай байна.

### Тав. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

#### Аймгийн ИТХ-ын дарга Л.Батсайхан-д:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аймаг, сумын ИТХ, иргэдийн нийтийн хурлаас тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулж, үр дүнг тооцож ажиллах.

#### Аймгийн Засаг дарга Н.Ганбямба-д:

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, аудитаар зөрчил дутагдал илэрсэн байгууллагын албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллах.

#### Аймгийн СТСХ-ийн дарга С.Нямдаваа-д:

3. Шилэн дансны цахим хуудсанд ангилал зөрүүлж цэс нээгдсэн байгууллагуудын ангиллыг залруулах арга хэмжээ авч ажиллах.

#### Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга О.Алтантуяа-д:

4. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахад гарч байгаа бэрхшээлтэй асуудлыг судлан нэгтгэж Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлэх.
5. Шилэн дансны цахим хуудсанд байгууллага, албан тушаалтны байршуулсан мэдээллийн утга агуулгыг үнэн зөв, иж бүрэн байдал, хугацаанд нь байршуулсан эсэхэд хяналт тавьж, үр дүнг Засаг даргын зөвлөлд танилцуулж байх

Дээрхи зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж Төрийн аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 15-ны дотор албан бичгээр ирүүлэх.

**Зургаа. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ**

Тайлангийн төсөлтэй танилцаад СХАА-аас ирүүлсэн санал:





**Долоо. ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ**



**Найм. ХАВСРАЛТУУД**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн судалгаа /1-5 маягт/

